



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/627

Зуунмод

Комиссын дарга томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/480 дугаар тушаалын 1.4, 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын даргаар Эрүүл мэндийн газрын дарга (С.Мөнхтуяа)-ыг томилсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (С.Мөнхтуяа)-т, комиссын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулан, шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусган ажиллахыг Эрүүл мэндийн газарт тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны “Комисс томилох тухай” А/67 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122611788